

Авто замын салбарт 2019 онд Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
1. Он дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд:							
1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд:							
1	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км хатуу хучилттай авто зам	"Хурдны зам" ХХК	2012.06.04-2018.10.30	99.2%	0.0%	99.2%	Тус авто замын 100км авто замыг бүрэн дуусгаж, 2017 онд улсын ашиглалтад өгсөн. 2018 онд үлдэгдэл ажлыг хийж гүйцэтгэсэн боловч хамгаалалтын төмөр хашлагын хүрэлцэхгүй тул ЗТХС-ийн 2018.12.12-ны хуралдаанаар хэлэлцүүлж, Сангийн яаманд хүсэлт хүргүүлсэн. Гэвч хөрөнгийг шийдвэрлэх боломжгүй хариу ирүүлсэн. Хөдөлгөөний аюулгүй байдал хангах хамгаалалтын төмөр хашлагыг хийгээгүй тохиолдолд улсын ашиглалтад өгөх нөхцөл бүрдэхгүй байгаа болно. Хамгаалалтын төмөр хашлагын хөрөнгө хүрэлцэхгүй тул 2020 оны улсын төсөвт тусгуулах санал өгсөн. Бусад бүх ажил бүрэн хийгдсэн.
2	Булган-Үенч-Ховд чиглэлийн 60 км хатуу хучилттай авто зам	"Жиансу Жунжиан Жианшин" ХХК	2013.06.27-2018.10.30	95.5%	95.6%	0.1%	Тус авто замын газар шорооны болон асфальтобетон хучилтын ажил бүрэн хийгдэж дууссан. Одоогоор замын төмөр туузан хашлага, тэмдэглэгээний ажил хийгдээгүй байна. 2013 онд байгуулсан зам барилгын ажлын гэрээнд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх зорилгоор нийт 224.5 сая төгрөгөөр 7.39 км туузан хашлага хийхээр тусгагдсан боловч өнөөдрийн байдлаар тухайн хөрөнгөөр зөвхөн 2.28 км туузан хашлагыг хийхээр байгаа ба үлдэгдэл 5.11 км туузан хашлага суурилуулах ажилд экспертизээр батлагдсан төсөвт өртгөөр 454.0 сая төгрөг шаардлагатай тооцоо гарсан бөгөөд одоогоор нэмэлт хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй байна. Уг нэмэлт хөрөнгийн эх үүсвэрийг 2020 оны Улсын төсөвт тусгахаар саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Төрийн нарийн бичгийн даргын тушаал 2019.05.30-ны өдрын тушаалын дагуу гүйцэтгэгч компанитай нэмэлт гэрээ байгуулахаар ажиллаж байна. Талбай дээр гүйцэтгэгч компанийн 10 ажилчид ажиллаж байгаа бөгөөд замын түмбэ суулгах ажил хийгдэж байна.
3	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 27 км хатуу хучилттай авто зам	"Хансуун зам" ХХК	2013.06.14-2019.10.30	99.0%	99.0%	0.0%	Уг авто замын барилга угсралтын ажлын явц 99%-тай байна. Гүйцэтгэгч компанитай нэмэлт гэрээ байгуулсан.Санхүүжилтийн асуудлаас болж үлдэгдэл ажлыг 2019 оны 6.10-ны өдрөөс эхлүүлэхээр болсон.
4	Гурванбулаг-Хишиг-Өндөр чиглэлийн авто замын төгсгөлийн хатуу хучилттай авто зам, 22 км /Булган/	"НКВ" ХХК	2018.05.18-2019.10.01	93.0%	95.0%	2.0%	Тэмдэг тэмдэглэгээ заслын ажил хийгдэж байна.Хоолойн орох гарах амсар болон чулуун бэхлэгээний ажил хийгдэж байна. Нийт 22км замын туршид анхааруулах, хориглох, мэдээлэх зэрэг 100ш тэмдэг, км-ийн заалт-22ш дохионы шон-288ш суулгахаас 270ш- ийг байрлуулсан байна. 3ш хоолойн орох гарах амсарын чулуун бэхлэгээ хийсэн. Бетонон зуурмагтай чулуун бэхлэгээтэй шуудуу 3000м хийгдсэн. Далан болон ухмалын хажуу налууг тэгшлэх ажил 90%тай хийгдэж байна. нийт. замын хэвтээ тэмдэглэгээний ажил эхлэх бэлтгэл хийгдэж байна. Талбайн цэвэрлэгээ 3км-т хийгдэж байна. Уулын шуудуу байгуулах ажил 36%тай хийгдэж байна. Хэвтээ тэмдэглэгээ нийт 62%тай хийгдэж байна.
5	Ширээгийн голын төмөр бетон гүүр, 90.9 у/м /Завхан, Цагаанхайрхан сум/	"ЗЗБ" ХХК	2018.05.14-2019.10.31	66.0%	66.0%	0.0%	Гүйцэтгэгч компани 2019 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2019.05.20-нд барилгын ажлыг эхлүүлсэн. Нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэж байна.
6	Согоогийн голын төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум/	"Жол" ХХК	2018.06.15-2019.10.30	99.0%	100.0%	1.0%	Гүүрийн барилгын ажил бүрэн дууссаж, цэвэрлэгээ болон заслын ажил хийгдэж байна.Комисс ажиллуулах албан тоот өгсөн.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
7	Намирын голын төмөр бетон гүүр, авто зам /Увс, Өмнөговь сум/	"Тэргүүн саруул зам" ХХК	2018.07.25 2019.10.31	71.0%	76.0%	5.0%	Гүйцэтгэгч компани 2019 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2019.05.01-нд барилгын ажлыг эхэлсэн. Барилгын ажил 76 хувьтай байна. ИТА-12, машин механизм-21, туслах ажилчид-47. Увс аймгийн Өмнөговь сумаас Улаангом чиглэлийн 5.3 км хайрган хучилттай авто замын ажил эхлээгүй байна. Увс аймгийн Өмнөговь сум 1.2км Бетон замын ажил хийгдэж байгаа тул 2 хэсгийн ажил түр хүлээгдэж байна..
8	Авто зам, гүүрийн барилга /Төв, Зуунмод сум, 2, 6 дугаар баг/ 0.4 км 16 у/м	"ЗЗБ" ХХК	2018.07.10 2019.10.30	99.0%	100.0%	1.0%	Гүйцэтгэгч компани 2019 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2019.04.15-нд барилгын ажлыг эхэлсэн.А/б хучилтын ажлыг 5/28 нд хийсэн.Зам барилгын ажил бүрэн дууссан комисс ажлуулах албан бичгийг ЗТХЯ-нд ирүүлсэн.
9	Баянхонгор-Арвайхээр чиглэлийн авто замын огцом эргэлтийг өөрчлөх, хатуу хучилттай авто зам, 4.4 км /Баянхонгор, Өлзийт сум/	"Их богд зам" ХХК	2018.10.05 2019.10.30	24.0%	27.0%	3.0%	Гүйцэтгэгч компани 2019 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2019.03.25-нд барилгын ажлыг эхэлсэн 24 хувьтай байна.Хоолойн ажил: пк1+880 , пк0+370 хоолойнуудын бетон суурь, тулц бетон, амсарын ул бетон цутгасан. Ухмал ухах ажил пк 3+600-пк 4+100, пк3+300-пк3+540 , пк4+240-пк4+360 хооронд хийгдсэн. Хатуу ухмал пк3+640 - пк3+940 Зам барилгын ажлын талбай дээр автосамосвал 11, Экскаватор 4/ Молодоктой экскаватор-1, / , Автогрейдр 1, Ачигч 1, Далангийн индүү-1, Үйлчилгээний машин 2. Инженер 3, Механизмчин 8, Жолооч 14, Туслах 3, Тогооч 2, манаач 1, хоолойн ажилчид-8, нийт 42 хүн ажиллаж байна.
10	Туул зэрлэг орчмын төмөр замын доорх автомашины нүхэн гарц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо/	"Туулын гүүр далай" ХХК	2018.05.21 2019.07.01	38.0%	38.1%	0.1%	Гүйцэтгэгч компани 2018 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт ажлын 38%-ийг хийж гүйцэтгээд байгаа бөгөөд 2019.05.15-ны өдөр барилгын ажил эхэлсэн.Цонхны ажлын хуваарийг хүлээж байна. Бэлтгэл ажил бүрэн хангагдсан.
11	Туул голын Сонгинын төмөр бетон гүүр, 200 у/м /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/	"ЗМЗ" ХХК	2018.07.28 2019.10.30	69.0%	70.0%	1.0%	Гүйцэтгэгч компани 2018 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт ажлын 45%-ийг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2019.05.01-ний өдөр эхэлсэн.Завсарын тулгуур - 8ш-ээс 6-н хийгдсэн Цутгамал ригель-8ш--ээс 6-н хийгдсэн Эргийн тулгуур-2ш, Дам нуруу-45ш хийгдсэн байна.
12	Гэр бүл, ёслолын ордон хүртэлх авто замын гүүр, авто зогсоол /УБ, Баянгол дүүрэг/	"Ди Ди Эм Эс " ХХК	2018.07.16	86.0%	86.0%	0.0%	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажил бөгөөд зураг төслийн өөрчлөлтөөс шалтгаалж хугацаа алдсан. Гэрээг сунгаж нэмэлт гэрээ байгуулсан. Барилгын ажил 2019.05.01 -ний өдөр эхэлсэн 86 хувьтай.Энэ 7 хоногт санхүүгийн асуудлаас болж ажил хийгдээгүй..
13	Наадамчдын замын уулзвараас Яармагийн автобусны шинэ эцсийн буудал хүртэлх хатуу хучилттай авто зам /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	"Бумбат даваа" ХХК	2018.07.10 2018.10.31	92.0%	92.0%	0.0%	Гүйцэтгэгч компани 2018 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт ажлын 92%-ийг хийж гүйцэтгэсэн бөгөөд гэрээ сунгаж нэмэлт гэрээ байгуулсан.Барилгын ажил эхлээгүй байна. Гүйцэтгэгч компани 2018 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт ажлын 92%-ийг хийж гүйцэтгэсэн бөгөөд гэрээ сунгаж нэмэлт гэрээ байгуулсан. Барилгын ажлыг яаралтай эхлүүлэх талаар албан тоотыг "Бумбат даваа" ХХК-д хүргүүлэв.
14	Халуун усны байрнаас Их наран, Их нарангаас Буяны зам хүртэлх хатуу хучилттай авто зам, 1.2 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	"Монгол зам групп" ХХК	2018.11.13 2019.11.15	30%	32%	2.0%	Гүйцэтгэгч компани 2018 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт ажлын 30%-ийг хийж гүйцэтгээд байгаа бөгөөд барилгын ажил 2019.05.15-ны өдөр эхэлсэн. Их нарангаас Буяны зам хүртэлх хатуу хучилттай авто замын трассын дагууд байгаа оршин суугчдаас гомдол гарсан тул 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр барилгын ажлын талбайд ЗТХЯ-ны ЗЗАХ-ийн дарга Х.Оргил-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, мэргэжилтэн Ч.Сугармаа нар ажиллаж тухайн асуудлыг шийдвэрлэсэн. Барилгын ажил графикийн дагуу явагдаж байна. Мэдээний хамрах хугацаа нь 2019.05.31-2019.06.06 Энэ хугацаанд "Монгол зам групп"ХХК нь ПК0+62-пк0+80-д байрлах гүүрийн суурийн арматур зангидаж хэв хашмалыг угсрах ажлыг хийж 2019-06-05-ны өдөр суурийн бетон цутгалтыг хийгдэв. 10*10*10см боржин чулуун хучилтыг 95 м, авто замын хашлагыг 260м*2 нийт 520м -т суурилуулав.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
15	Аймгийн төвийн авто замын өргөтгөл, шинэчлэлт, 10.4 км /Баян-Өлгий, Өлгий сум/	"Жол" ХХК	2018.08.07 2019.11.15	48%	50%	1.5%	Гүйцэтгэгч компани батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт ажлын 49.5%-ийг хийж гүйцэтгээд байна. Далангийн дүүргэлт, суурийн доод үе, авто замын хашлага, явган хүний замын хавтангийн ажил хийгэж байна. Нийт 38 ажилтан, 13 машин механизм ажиллаж байна.
16	Баянбулагийн 2 дугаар гудамжнаас Мандал овооны 3 дугаар гудамж хүртэлх хатуу хучилттай авто зам, 1.5 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	"Оч наран" ХХК	2018.11.12 2019.11.15	5%	5%	0.0%	Гүйцэтгэгч компани 2018 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт ажлын 5%-ийг хийж гүйцэтгээд байгаа бөгөөд барилгын ажил 2019.05.15-ны өдөр эхэлсэн боловч газар чөлөөлөлтийн асуудлаас шалтгаалж графикт хугацаандаа ажлыг гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүсээд байна. Иймээс нийслэлийн газрын алба, зураг төслийг гүйцэтгэгч "Ихэр мөнх" ХХК болон зөвлөх "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын хяналтын инженерийг байлцуулан уулзалт зохион байгуулахаар шийдвэрлэсэн./2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр барилгын ажлын талбайд ЗТХЯ-ны ЗЗАХ-ийн дарга Х.Оргил-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, мэргэжилтэн Ч.Сугармаа нар ажилласан./ /85 орчим айл өрх газар чөлөөлөлтөд өртсөн байсныг 43 орчим болгож өөрчлөхөөр зурагт өөрчлөлт оруулж байна/
1.2. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд:							
17	Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам	"Шанхай Констракшн Групп" ХХК	2016.04.15- 2019.10.30	90.7%	92.0%	1.3%	Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 180 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.04.01-ний өдөр эхлүүлсэн.Талбай дээр 134 тоног төхөөрөмж, 226 ажилтан ажиллаж байна. Барилгын ажлын талбай дээр суурийн ажил хийгдэж дууссан бөгөөд хучилтын ажил 94%-тай хийгдээд байна.
18	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам	"Шинжиан Бэйшин Роуд энд Бридж Групп" ХХК	2016.04.15- 2019.10.30	99.4%	99.4%	-99.3%	Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 35 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.05.25-ны өдөр эхлүүлсэн. Барилгын ажлын талбай дээр хоолойн орох гарах амсрын далангийн бэхэлгээний ажил, өөрийн шуудуу ухах, хөвөөний тэгшилгээний ажлууд, асфальтбетон хучилт засварлах ажлууд хийгдэж байна. Талбай дээр 48 тоног төхөөрөмж, 20 инженер техникийн ажилчид ажиллаж байна.
19	Улаанбаатар-Хөшигийн хөндийн Олон улсын шинэ нисэх буудал чиглэлийн 32.226 км хурдны авто зам	"Чайна Тэйсэжү Сивил Инженеринг Групп" ХХК	2015.08.04- 2019.10.30	99.2%	99.3%	0.1%	Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 60 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.04.01-ний өдөр эхлүүлсэн бөгөөд 2019.07.10-ны өдрийн дотор барилгын ажлыг бүрэн дуусгаж, улсын ашиглалтад оруулна. Талбай дээр 37 тоног төхөөрөмж, техник хэрэгсэл байгаа ба 205 (Монгол 187, БНХАУ-ын 18) ажилтан ажиллаж байна. Барилгын ажлын талбай дээр габион 100%, хажуу налууг ургамлын үеэр бэхжүүлэх 61.40%, хайрга, чулуун налуугийн хамгаалалт 100%, торон хашаа суулгах 98.84%, туузан хашлага 99.84%, замын тэмдэг 43.84%, км-ын тэмдэг 80%, тэмдэглэгээний ажлууд 81.53%-тай хийгдэж байна.
20	Багц 1: Хашаатын даваа-Шургын гүүр чиглэлийн 50 км	"Чайна Хуаши Энтерпрайзис Лимитед" ХХК	2015.08.30- 2018.10.30	96.0%	96.0%	0.0%	Зам барилгын ажил 2018 онд хэрэгжиж дууссан. 2018 оны 12 дугаар сарын 17-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. 2019 оны зам барилгын улиралд баталгаат засварын хугацаанд хэрэгжүүлэх жижиг хэмжээний засал, мэдээллийн самбар байрлуулах, карьер болон замын ухмал хэсгийн налууг зүлэгжүүлэх, тэмдэг тэмдэглэгээг тодотгох зэрэг ажлуудыг хийж байна. Одоогоор ажлын талбайд нийт 23 ажилтан /6 гадаад, 17 Монгол ажилчин/, 9 техник ажиллаж байна.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
21	Багц 2: Шургын гүүр-Ховд чиглэлийн 53.9 км	"Эйч Кей Би Интернэйшл Холдинг" ХХК	2015.08.30-2018.10.30	98.0%	98.0%	0.0%	Зам барилгын ажил 2018 онд хэрэгжиж дууссан. 2018 оны 12 дугаар сарын 17-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. 2019 оны зам барилгын улиралд баталгаат засварын хугацаанд хэрэгжүүлэх жижиг хэмжээний засал, мэдээллийн самбар байрлуулах, карьер болон замын ухмал хэсгийн налууг зүлэгжүүлэх, тэмдэг тэмдэглэгээг тодотгох зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна. Одоогоор ажлын талбайд нийт 22 ажилтан /14 гадаад, 8 Монгол ажилчин/, 38 техник ажиллаж байна.
22	Баруун босоо тэнхлэгийн авто замаас Мөст сум хүртэлх 20.3 км хатуу хучилттай авто зам	"Хотгор зам" ХХК		6.7%	13.0%	6.3%	Барилгын ажил 2019.05.01-нээс эхэлсэн. Далангийн дүүргэлтийн ажил, чулуу бутлах зэрэг ажил хийгдэж байна. Ажлын талбайд нийт 80 ажилтан, 37 техник, тоног төхөөрөмж ажиллаж байна.
23	Багц 3: Хашаатын даваа-Толбо сум чиглэлийн 60 км	"Чайна Хуаши Энтерпрайзис Лимитед" ХХК	2015.08.30-2019.09.30	59.2%	59.5%	0.3%	2018 оны жилийн эцсийн байдлаар зам барилгын ажил 57.8%-тай. Гэрээгээр зам барилгын ажлыг 2019 оны 09 оны 30-ны өдөр дуусгаж, ашиглалтад оруулна. 2019 оны зам барилгын ажил 2019 оны 04 дүгээр сарын 01-нд эхсэн. 2019 оны 06 дугаар сарын 06-ны байдлаар барилгын ажлын хувь 59.5 хувьтай. Ажлын талбайд нийт 292 ажилтан /154 гадаад ажилтан, 138 Монгол ажилтан/, 140 техник, тоног төхөөрөмж ажиллаж байна.
1.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барих-шилжүүлэх нөхцөлөөр концессын гэрээгээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд:							
24	Сонгино-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам /Концесс/	"Шинжиан Шинфа" ХХК	2017.02.03-2018.11.30	94.0%	94.0%	0.0%	Зам барилгын ажлыг үргэлжлүүлэх 06/10/2017 дугаартай зөвшөөрлийг 2017.09.14-ний өдөр олгосон. Концесс эзэмшигчээс ажил үргэлжлүүлэх зөвшөөрлийн хугацааг 2018.11.30-ний өдөр хүртэл сунгасан. Далан, ухмал, дэд суурь, цементээр бэхжүүлсэн суурь, хиймэл байгууламжийн ажил, суурь хучилт 100%, өнгө хучилт 83.3 км хийгдээд байна. Эхний 83.3 км замыг 2018 оны 12 сард ашиглалтад хүлээн авсан. Одоогоор 52км өнгө асфальтбетон хучилт болон заслын ажил үлдсэн бөгөөд 7 сард багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн, хучилтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна.
25	Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам.	"Монгол Л3 зам гүүр" ХХК	2017.11.28-2019.10.31	57.9%	59.7%	1.8%	Зам барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр олгосон. Гүйцэтгэгч компани 2018 онд батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт ажлын 53%-ийг хийж гүйцэтгэсэн. 2019 оны зам барилгын ажлыг 4 дүгээр сарын 25-ны өдөр эхлүүлсэн. Зам дээр нийт 665 /монгол-185, хятад-481/ ИТА, 165 ширхэг тоног төхөөрөмж, машин механизм ажиллаж байна. Зам барилгын ажлын талбайд далангийн дээд үе, суурийн доод үе, төмөр бетон хоолойн хэв угсрах, цутгалт хийх, буцаан дүүргэлт, буталсан чулуун суурь, хөвөө хайрцаглах ажлууд хийгдэж байна. Нийт ажлын явц 59.7 %.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
26	Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам.	"Эрчим хүчний барилга угсралтын трест" ХХК	2018.02.05-2019.12.01	12.0%	12.3%	0.3%	Концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр Хөрөнгө оруулалтын газраас /хуучнаар/ "Эрчим хүчний барилга угсралтын трест" ХХК-тай 2015.08.15-ны өдөр концессын гэрээ байгуулсан. Концесс эзэмшигч "Эрчим хүчний барилга угсралтын трест" ХХК нь гүйцэтгэгч "Монроуд" ХХК-тай гэрээгээ сунгасан бөгөөд 2018 оны 5 сарын 15-ны өдрөөс зам барилгын ажлыг эхлүүлсэн ба 12.9 хувийг хийж гүйцэтгэсэн. Зам, тээврийн сайдын 2019.03.14-ний өдрийн 75 дугаар тушаалаар тус төслийн хэрэгжилтийг судлан, эрчимжүүлэх арга хэмжээний санал боловсруулах Үндэсний хөгжлийн газартай хамтарсан ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсгээс дүгнэлтээ гарган Засгийн газарт танилцуулсан. Засгийн газрын 2019.04.10-ны өдрийн хуралдаанаар уг концессын эзэмшигчийн эрх, үүргийг "Макс рөүд" ХХК-д шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гэрээний хэлцэл хийж, 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр "Макс рөүд" ХХК-тай концессын гэрээ байгуулсан бөгөөд концесс эзэмшигч "Макс рөүд" ХХК нь зам барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллахаар болсон бол Зөвлөхөөр "Аварга зам" ХХК үргэлжлүүлэн ажиллаж байна. "Макс рөүд" ХХК нь Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замыг гэрээт хугацаанд нь ашиглалтад оруулахаар төлөвлөн нүүлгэн шилжүүлэлт, хэмжилт дурандлага хийх, кемп байгуулах зэрэг бэлтгэл ажлыг ханган, ухмал, далангийн дүүргэлтийн ажлыг эхлүүлээд байна. Мөн өмнөх концесс эзэмшигч болон ерөнхий гүйцэтгэгч "Монроуд" ХХК-тай өмнө хийгдсэн ажлын тоо хэмжээг нарийвчлан тогтоох ажил хийж байна.
27	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум чиглэлийн 120 км хатуу хучилттай авто зам.	"Шинжиан Шинфа" ХХК	2017.10.11-2019.10.30	20.0%	20.0%	0.0%	Концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газраас "Шинжиан Шинфа" ХХК-тай 2017.01.12-ны өдөр концессын гэрээ байгуулсан. Концесс эзэмшигчээс далан, ухмал, хиймэл байгууламжийн ажил гүйцэтгэж байгаа бөгөөд ойролцоогоор нийт ажлын 20%-ийг хийж гүйцэтгэсэн талаар Үндэсний хөгжлийн газарт мэдээ өгсөн боловч эдгээр ажил нь Зөвлөхөөр баталгаажуулаагүй байна. Үүнтэй холбоотой шалгах ажиллагааг эрх бүхий байгууллагаас хийж байна.
2. Шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээнүүд:							
2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд:							
28	Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/		2007-2019				Орон нутгаас хучилтын хийцийг өөрчилж, нэмэлт хөрөнгийн асуудал шийдвэрлүүлэх хүсэлт ирүүлсэн. Тухайн асуудал шийдэгдсэний дараа гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажил зохион байгуулахаар төлөвлөж байна.
29	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	-	2019-2020	-			ТНБД-ын 2019 оны 40 дүгээр тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2019.02.27-ны өдөр зарласан бөгөөд 2019.04.01-ний өдөр нээсэн. Үнэлгээний хороо тендерийг үнэлж, шаардлагад нийцсэн нэг ч оролцогч оролцоогүй тул хуулийн дагуу хүчингүй болгосон.
30	Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 50 км /Хэнтий, Бор-Өндөр сум/	"Билэгт зам" ХХК	2019-2020	3.00%	6.00%	3.00%	ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Үнэлгээ хийгдэж байна. Гүйцэтгэгчээр "Билэгт зам" ХХК-д 2019.04.02-ны өдөр гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж, гэрээ байгуулсан. БУА-ыг эхлүүлсэн. Хөрс хуулалтын ажил далангийн дүүргэлтийн ажил явагдаж байна. Гүүрийн католван ухах, 3-н хоолойн суурь ухах ажил хийгдэж байна.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
31	Орхон-Хишиг-Өндөр сум чиглэлийн хатуу хучилттай авто замын эхлэл /Булган/	"Наранбулагхан" ХХК	2019-2020	5.00%	7.00%	2.00%	ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр сонгон шалгарсан "Наранбулагхан" ХХК-тай гэрээ байгуулсан.5 км замын хөрс хуулсан.Ухмалын ажил хийгдэж байна.Барилгын ажлын талбайн ИТА Төслийн удирдагч-1, Ерөнхий инженер-1, Талбайн инженер-1, Материалын инженер-1, Геодезийн инженер-1, жолооч-6, оператор-3, туслах ажилтан-6 нийт-20 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж байна. Барилгын ажлын машин механизм Экскаватор-3 автогэйдер-1 Автосамсомол-5 индүү-1 үйлчилгээний машин-2 12.8км-т тэнхлэгээ шилжүүлж гадсалгаа хийсэн хэмжилтийн ажил хийгдэж байна 5км хөрс хуулалтын ажил хийгдэж байна.Ухмалын ажил эрчимтэй хийгдэж байна. Карьерийн материалын шинжилгээ хийгдэж шинжилгээгээр тэнцсэн нөөц багатай байна. Зурагт тусгагдсан шороон орд шинжилгээгээр тэнцээгүй болно.
32	Мандалын голын төмөр бетон гүүр, 62 у/м /Баянхонгор, Галуут сум/	"Эвт-Уул" ХХК, "ЗЗБ" ХХК -ийн түншлэл	2019.0315-2019.10.30	0.50%	0.50%	0.00%	ЗТХЯ-наас тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр "Эвт-Уул" ХХК, "ЗЗБ" ХХК -ийн түншлэлд 2019.03.15-ны өдөр гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж, гэрээ байгуулсан.Нүүлэн шилжүүлэлтийн ажил хийгдэж байна.Улаан шугам яаралтай хүлээлцэх албан тоот өгсөн.
33	Орхон голын Онгоцтойн амны төмөр бетон гүүр, 220 у/м /Өвөрхангай, Бат-Өлзий сум/	"Моторсервис" ХХК	2019-2020	0.00%	1.00%	1.00%	ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр сонгон шалгарсан "Мотор сервис" ХХК-тай гэрээ байгуулсан.Хяналтын инженер томилсон.БУА-г эхлүүлэх зөвшөөрлийг олгосон.Нүүлэн шилжүүлэлтийн ажил хийгдэж байна.
34	Аймгийн төвийн авто зам, гэрэлтүүлэг /Ховд, Жаргалант сум, Наран баг/	"Түм дэлгэрэх" ХХК	2019-2020	1.00%	1.00%	0.00%	Барилгын ажил гүйцэтгэх гэрээг 2019 оны 5 сарын 13-нд байгуулсан. Нүүлэн шилжүүлэлт хийж, барилгын ажлыг эхэлсэн боловч газар чөлөөлөлтийн асуудал үүссэн. Зураг зохиогч "гео зураглал" ХХК-иас тодруулга авч, Захиалагч байгууллага болох орон нутагт уг асуудлыг шийдвэрлэх талаар албан тоот хүргүүлж байна. Барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон.Хяналтын инженер томилсон.БУА-г эхэлхээр бэлтгэл ажлыг хангаж байна.
35	Аймгийн төвийн авто зам, зогсоолуудын шинэчлэл /Баян-Өлгий, Өлгий сум/	"Жол" ХХК	2019-2020	-			ЗТХЯ-наас тендерийг зарласан. "Жол" ХХК-тай 2019.05.13-ны өдөр гэрээ байгуулсан
36	Бодонч, Ангиртын голын төмөр бетон гүүр, 40 у/м /Ховд, Алтай сум/		2019	-			ТӨБЗГ- Тендер зарлагдаагүй байна.
37	Сумын төвийн 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбох авто замын гүүрэн гарц /Дархан-Уул, Дархан сум/		2018-2019	-			ТНБД-ын 2019 оны 39 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2019.03.06-ны өдөр зарласан бөгөөд 2019.04.08-ны өдөр нээсэн боловч тендер шалгаруулалтад нэг ч оролцогч ирээгүй . Дархан-Уул аймгийн ЗДТГ-аас ирсэн хүсэлтийн дагуу уг төсөл, арга хэмжээг ЗТХСайдын 2019.05.01-ний өдрийн 130 дугаар тушаалаар орон нутгат эрх шилжүүлсэн
38	Ноён сумаас Сухайт хүртэлх сайжруулсан шороон зам, 20 км /Өмнөговь, Ноён сум/	"Даблю экс пи" ХХК, "Энх төгөл бэх" ХХК-иудын түншлэл	2019.05.14-2020.10.30	4.00%	9.00%	5.00%	ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч Сангийн яаманд гомдол гаргаж, тендерийг түр түтгэлзүүлсэн. Сангийн яамнаас тус яамны шийдвэрийг үндэслэлтэй гэсэн шийдвэр гарсан тул гүйцэтгэгчээр сонгон шалгарсан "Даблю экс пи" ХХК, "Энх төгөл бэх" ХХК-иудын түншлэлтэй 2019.05.14-ний өдөр гэрээ байгуулсан.Барилгын ажлыг эхлүүлсэн. Хөрс хуулалт далан байгуулах ажил хийгдэж байна.
39	Чингис хот-Бэрх чиглэлийн аялал хатуу хучилттай авто замын эхлэл, 20 км /Хэнтий/	Наранбулагхан " ХХК, "Анандын зам" ХХК-ийн түншлэл	2019-2020	4.00%	30.00%	26.00%	ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр "Наранбулагхан" ХХК, "Анандын зам" ХХК-ийн түншлэл шалгарч гэрээ байгуулсан.Барилгын ажлыг эхлүүлсэн. Далан байгуулах, ухмал ухах, хоолойн суурь ул бетон 12 хэсэгт цутгасан.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
40	Онон голын төмөр бетон гүүр, 150.0 у/м /Хэнтий, Баян-Адарга сум/	"Гангүүр" ХХК	2019-2020	5.00%	13.00%	8.00%	ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр "Гангүүр" ХХК-д 2019.04.06-ны өдөр гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж, гэрээ байгуулсан.БУА эхлүүлсэн.Талбай дээр ИТА-4, машин механизм-8, ажиллах хүч-27. Нийт 39 хүн ажиллаж байна. Захын тулгуурын 6 ш шон өрөмдөж бетон цутгасан. 24 м-ийн урттай 2 ширхэг дам нуруу цутгасан.
41	Онон голын төмөр бетон гүүрийн засвар 238.9 у/м /Хэнтий, Дадал сум/	"Гангүүр" ХХК	2019-2020	1.00	8.00	7.00	ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр "Гангүүр" ХХК-д 2019.04.06-ны өдөр гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж, гэрээ байгуулсан.Их засвар ажлыг эхлүүлсэн.Талбайд ИТА-2, Механизм-4, Ажиллах хүч-13. Нийт 19 хүн ажиллаж байна. 2 ригелийн 48 ш нүх өрөмдсөн. 24 ширхэг арматур суулгасан. 10 ширхэг дугуй цохигчийн арматур боосон.
42	Дөмөг захын уулзвараас 6 дугаар хороолол хүртэлх авто замын өргөтгөл, 2.1 км /Орхон, Баян-Өндөр сум/	"Жавхлан харгуй" ХХК	2019-2020	2.00%	3.00%	1.00%	ТӨБЗГ-аас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр "Жаргалан харгуй" ХХК-тай гэрээ байгуулсан.БУА эхэлсэн.Газар чөлөөлөлтийн ажил явагдаж байна.Талбайн цэвэрлэгээний ажил хийгдэж байна.
43	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 1.8 км /Булган, Булган сум, 4 дүгээр баг, Зүүн түрүү/	-	2019-2020	-	-	-	Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Тендерийн зарласан ба 2019.05.23-ны өдөр нээсэн. ТШ-д 2 оролцогч оролцсон бөгөөд үнэлж байна.
44	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлын эхлэл /Дархан-Уул, Шарын гол сум/	"Төгс зам" ХХК	2019-2020	3.00%	5.00%	2.00%	ТӨБЗГ-аас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан.Гүйцэтгэгчээр "Төгс зам" ХХК шалгарч гэрээ байгуулсан.БУА эхлүүлсэн.Хөрс хуулалт, ухмалын ажил хийгдэж байна.Мөн 250ш 1ф хоолой татсан, бутлуур нүүлгэж ирсэн.
45	Сумын доторх хатуу хучилттай авто зам, 2.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	"Хөвчийн зам" ХХК	2019-2020	-	-	-	"Хөвчийн зам" ХХК шалгарч гэрээ байгуулсан.Улаан шугамыг 2019.06.04-ний өдөр хүлээлцэнэ.Барилгын ажлыг 2019.06.06-ны өдөр эхлүүлнэ.
46	"Улаанбаатар Палас"-ын хойд талын үерийн далан дагасан авто замыг 3 дугаар эмнэлгийн арын замтай холбох авто зам /Улаанбаатар, Баянгол дүүрэг 6 дугаар хороо/	"Алтан малгайт" ХХК	2019	-	-	-	ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр "Алтан малгайт" ХХК шалгарч 2019 оны 05 дугаар сарын 29-нд гэрээ байгуулсан.Улаан шугам хүлээлцэх албан тоотыг зураг төсөл гүйцэтгэгч компанид хүргүүлээд байна.
47	Баруун салааны автобусны эцсийн буудлаас Бумбатын рашаан чиглэлийн хатуу хучилттай авто зам, 3.61 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо/	-	2019-2020	-	-	-	Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Тендерийг зарласан бөгөөд 2019.04.22-ны өдөр нээсэн. Үнэлж байна.
48	Баянбүрдийн тойрог орчмын авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7,8,9,10,11 дүгээр хороо/	-	2019	-	-	-	Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Зураг төслийн ажлын даалгавар НАЗХГ-аас ирсэн даруй ТӨБЗГ-т хүргүүлнэ. Түүний дараа ТШ-ыг зохион байгуулна.
49	Гэр хорооллын дундах хатуу хучилттай авто зам /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 1, 2, 22 дугаар хороо/	-	2019	-	-	-	Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Зураг төслийн ажлын даалгавар НАЗХГ-аас ирсэн даруй ТӨБЗГ-т хүргүүлнэ. Түүний дараа ТШ-ыг зохион байгуулна.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
50	Дарь-Эхийн авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээ, 3.2 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	-	2019	-			Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Зураг төслийн ажлын даалгавар НАЗХГ-аас ирсэн даруй ТӨБЗГ-т хүргүүлнэ. Түүний дараа ТШ-ыг зохион байгуулна.
51	Дүүргийн доторх авто зам, явган хүний зам /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	-	2019	-			Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Зураг төслийн ажлын даалгавар НАЗХГ-аас ирсэн даруй ТӨБЗГ-т хүргүүлнэ. Түүний дараа ТШ-ыг зохион байгуулна.
52	Зүүн салааны автобусны эцсийн буудлаас Богинын ам, Ухнын амын уулзвар хүртэлх хатуу хучилттай авто зам, 2.4 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 25 дугаар хороо/	-	2019-2020	-			Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Тендерийг зарласан бөгөөд 2019.04.22-ны өдөр нээсэн. Үнэлж байна.
53	Морингийн давааны хатуу хучилттай авто зам, 1.2 км /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/	"Заабар" ХХК	2019-2020	0.00	2.00%	2.00%	ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр шалгарсан "Заабар" ХХК-тай гэрээ байгуулсан.Нүүлгэн шилжүүлэх ажил болон карьерын судалгааны ажил хийгдэж байна.
54	Нисэхийн эцсийн автобусны буудлаас Буянт-Ухаа 21 дүгээр гудамж хүртэлх хатуу хучилттай авто зам, 2.8 км /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 9 дүгээр хороо/	"Ди Вай Кэй Ви" ХХК	2019-2020	-			ЗТХЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Гүйцэтгэгчээр шалгарсан "Ди Вай Кэй Ви" ХХК-д гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн.
55	Ривер Хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх авто зам, зогсоол, 1 км /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 11 дүгээр хороо /	-	2019-2020	-			Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. ТШ-ыг зарласан бөгөөд 2019.07.01-ний өдөр нээгээ.
56	Тасганы овооноос хороодын нутаг дэвсгэрийн хилийн цэсийн дагуу Самбалхүндэвийн эргэмжийн газрын авто замтай нийлэх хатуу хучилттай авто зам, 2.6 км /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	-	2019-2020	-			Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Зураг төслийн ажлын даалгавар НАЗХГ-аас ирсэн даруй ТӨБЗГ-т хүргүүлнэ. Түүний дараа ТШ-ыг зохион байгуулна.
57	Хороодын дундах хатуу хучилттай авто зам, чулуун зам шинээр тавих /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/	-	2019	-			Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Зураг төслийн ажлын даалгавар НАЗХГ-аас ирсэн даруй ТӨБЗГ-т хүргүүлнэ. Түүний дараа ТШ-ыг зохион байгуулна.
58	Хорооллын доторх авто зам, 1.75 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13, 14 дүгээр хороо/	-	2019-2020	-			Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Тендерийг зарласан бөгөөд 2019.04.26-ны өдөр нээсэн боловч нэг ч оролцогч оролцоогүй тул тендерийг дахин зарласан.
59	Гашууны голын төмөр бетон гүүрийн их засвар, 72.0 у/м /Увс, Улаангом сум/	"Тэргүүн саруул зам" ХХК	2019-2020	1.00%	1.00%	0.00%	Гэрээ байгуулагдсан. Хяналтын инженер томилогдсон. Ажил эхлүүлэх зөвшөөрөл гарч, ажлыг эхлүүлсэн. Бэлтгэл ажил хийгдэж байна.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
60	Хорооллын доторх авто замын засвар, 3 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо/	"Зам, гүүр барилгын нэгдэл" ХХК	2019	1.00%	12.00%	11.00%	БУА-ыг эхлүүлсэн. Авто замын хашлага тавьсан. Цэвэр, бохирын худаг 15 ширхэгийг өндөрлөсөн.
61	Шар хоолойн хатуу хучилттай авто зам, 4.7 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, Гачуурт тосгон/	-	2019-2020	-			Зам, тээврийн хөгжлийн сайд, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 06/А/09 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжсэн. Тендерийг зарласан бөгөөд 2019.04.26-ны өдөр нээсэн. Үнэлж байна.
2.2. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд:							
62	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төслийн монголын талын хөрөнгө /Улаанбаатар/	Синохидро корпораци лимитед компани	2018-2019	6.4%	16.0%	9.6%	Уг төслийн гүйцэтгэгчээр Синохидро Корпорейшн Лимитед компани 2016 онд шалгарч гэрээ байгуулсан. Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 300 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Бэлтгэл ажлын хүрээнд түр замын барилгын ажил дууссан ба энэхүү авто замын трасст орсон цахилгааны шугам, холбооны кабель, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээг зөөх, шилжүүлэх, хүчитгэх, ажлын 80 орчим хувийг гүйцэтгээд байна. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.04.15-ний өдөр эхлүүлээд байна. Барилгын ажлын талбай дээр хуучин цементбетон хавтанг хуулах болон газар шорооны ажил /хөрс хуулалт, ус зайлуулах байгууламжийн суурийн ухмал, замын ухмал, далангийн ажил/ хийгдэж байна.
63	Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн, шинэчлэн төсөл: АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжих "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 км одоо байгаа авто замыг өргөтгөн, шинэчлэх ажил		2019-2020	0.00%			АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжих "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 км одоо байгаа авто замыг 4 эгнээ болгон өргөтгөхтэй уялдуулан өргөтгөж, шинэчлэх ажлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Зураг төслийг бэлэн болгож, АХБ-аас зөвшөөрөл авсан. Зам барилгын ажлыг 5 багц хэсгээр зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын өрсөлдөөнт тендерийг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу 2019 оны 03 сарын 21-нд зарласан. Зам барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөхийг сонгон шалгаруулах ажлыг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Зөвлөх, гүйцэтгэгчийг 5 дугаар сард сонгон шалгаруулж, гэрээ байгуулна. Зам барилгын ажлыг 2019 оны 11 сард дуусгаж, хөдөлгөөн нээхээр төлөвлөн ажиллаж байна.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
64	Багц 4: Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км	-	2019-2020	0.0%			Зам барилгын ажлын гүйцэтгэгчийн тендерт Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 834 дугаар бүхий шийдвэр гарсан. Тус шийдвэрээр тус багцад 2018.05.11-ний өдөр "Алтайн зам" ХК-тай барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан боловч АХБ-аас тус банкны Худалдан авах ажиллагааны журамд нийцэхгүй үндэслэлээр санхүүжүүлэхгүй боломжгүй гэж мэдэгдсэн. АХБ-аас тус зам барилгын ажлын гүйцэтгэгчийн тендерт гарсан шүүхийн шийдвэр хүчингүй болсон тохиолдолд АХБ-ны хөрөнгө оруулалтыг ашиглах боломжтой талаар мэдэгдлийг 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн. Шүүхийн шийдвэр хэрэгжсэн талаарх тодорхойлолт хүссэн албан бичгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдөр 01/1028 дугаар бүхий албан бичгээр хүргүүлсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2019 оны 03 сарын 21-ний өдрийн 1/7099 албан тоотой хариу ирүүлсэн бөгөөд шүүхийн шийдвэр хэрэгжсэн талаарх тодорхойлолтыг ирүүлсэн. АХБ-нд шүүхийн шийдвэр хэрэгжсэн тул тус банкны хөрөнгөөр зам барилгын ажлыг хэрэгжүүлэх, мөн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын ажлыг эхлүүлэх хүсэлтийг 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хүргүүлсэн. АХБ-аас хариу хүлээгдэж байна.
65	"Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн замаас Мөст сум чиглэлийн 20.3 км хатуу хучилттай авто зам	"Хотгор зам" ХХК	2018-2019	5.0%			Зам барилгын ажлын гүйцэтгэгчээр "Хотгор зам" ХХК шалгарч 2018 оны 11 сарын 17-нд гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч байгууллага нь 2018 онд авто замын чиг сэргээх хэмжилт хийх, ажлын талбайд тоног төхөөрөмж нүүлгэн шийлжүүлэх, карьерийн байршил тогтоох зэрэг бэлтгэл ажлыг ханган ажилласан. 2019 оны зам барилгын ажил 04 сарын 01-нд эхэлсэн. 10 км-т хөрс хуулалт х ийсэн, 5 км-т далангийн 1-р үе хийсэн. Барилгын талбайд материал татан авалт хийгдэж байна.
66	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам	"Чайна Коммуникэйшн Констракшн" ХХК	2018.03.12-2020.10.30	-			Уг авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Чайна Коммуникэйшн Констракшн" ХХК шалгарч 2018 онд тус яамтай гэрээ байгуулсан. Тус авто замын барилгын ажилд өдөр тутмын техник, технологийн хяналт тавих зөвлөхийн үйлчилгээний зардлыг 2019 оны Улсын төсвийн урсгал зардалд тусгаж шийдвэрлэсэнтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зөвлөхөөр шалгарсан "Мөнхөд ашдын зам" ХХК-тай 2019.06.05-ны өдөр гэрээ байгуулаад байна. Тус яамнаас томилогдсон Ажлын хэсэг Завхан аймагт 2019.05.22-26-ны өдрийн хооронд албан томилолтоор ажиллаж, гүйцэтгэгч компанид улаан шугамыг хүлээлгэн өгсөн бөгөөд барилга угсралтын ажлыг 2019.06.10-ны өдөр эхлүүлэхээр гүйцэтгэгч компани бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Бэлтгэл ажлын хүрээнд замын гадаслагаа, хэмжилтийн ажил болон түр кэмп болон техник, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх ажил хийгдээд байна.
2.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд:							
67	Шартээгийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам	Концесс эзэмшигч "Эн Си Эф" ХХК	2017.03.30-2018.10.30 гэрээг 2019.10.30 хүртэл сунгасан.	4.7%	4.90%	0.2%	Концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газраас "Эн Си Эф" ХХК-тай 2017.03.30-ны өдөр байгуулсан. Концесс эзэмшигч гэрээ хүчин төгөлдөр болох нөхцлүүдийг хангаж, 2017 оны 11 сард гэрээ хүчин төгөлдөр болсон тул Үндэсний хөгжлийн газраас зам барилгын ажилд өдөр тутмын хяналт гүйцэтгэх зөвлөх компани сонгон шалгаруулалтыг 2018.04.11-ний өдөр зарлан, үнэлгээ хийж, шалгаруулсан боловч оролцогчдоос шүүхэд гомдол гаргасан шалгаанаар гэрээ байгуулах ажил саатсан. Шүүхийн маргаан дуусгавар болсон тул концессын гэрээг 2019.10.30 хүртэл сунгасан бөгөөд Зөвлөхийн гэрээг 2019.04.13-ны өдөр байгуулснаар зам барилгын ажлыг эхлүүлэх нөхцөл бүрдсэн. Одоогоор замын чиг сэргээх, ухмал, далангийн ажил хийгдэж байна. Ажлын явц 4.9%.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Гүйцэтгэгч компани	Эхлэх, дуусах хугацаа	Өмнөх 7 хоногт (%)	Энэ 7 хоногт (%)	Өсөлт (%)	Тайлбар
68	Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км авто зам төсөл	Концесс эзэмшигч "Ундрах говь" ХХК	2018.12.04-ны өдөр гэрээ байгуулсан.	0.0%	0.0%	0.0%	Үндэсний хөгжлийн газраас концессын "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" гэрээг концесс эзэмшигч "Ундрах говь" ХХК-тай 2018.10.04-ны өдөр байгуулсан. Концессын хугацаа 22 жил 6 сар байна. Концесс эзэмшигч нь өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр төслийг бүрэн санхүүжүүлнэ. Гэрээнд заасны дагуу 6 сарын дотор концесс эзэмшигч нь гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлүүдийг ханган эрх бүхий этгээдэд хүргүүлэх бөгөөд эрх бүхий этгээд нөхцөл хангагдсан гэж үзвэл гэрээ хүчин төгөлдөр болсныг баталгаажуулах бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор авто замыг ашиглалтад оруулна. Авто зам ашигласны төлбөр тн тутамд 0.8 центээс ихгүй байна./НӨАТ-гүй/. Тухайн чиглэлийн замын ТЭЗҮ-г боловсруулан Авто замын салбарын ШУТЗ-өөр хэлэлцүүлэн зөвлөмжийн хамт замын чиглэлийг батлуулахаар тус яаманд хандсаны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.05.06-ны өдрийн 137 дугаар тушаалаар замын чиглэлийг нь баталж өгсөн. Замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.
69	Тавантолгой-гашуунсүхайд чиглэлийн 250 км авто зам төсөл	Концесс эзэмшигч "Тал нутгийн хөгжлийн зам" ХХК	2019.03.29-ны өдөр гэрээ байгуулсан.	0.0%	0.0%	0.0%	Төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг Концессын тухай хуулийн дагуу урьдчилсан болон уралдаант гэсэн 2 үе шаттайгаар уралдаант шалгаруулалтыг 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдөр 4 сарын хугацаатайгаар Үндэсний хэмжээний өдөр тутмын сонинд зарласан. Уралдаант шалгаруулалтад 2 түншлэл төслийн саналаа ирүүлсэн ба ирүүлсэн саналыг 2018.03.19-ний өдөр хүлээн авч, комисс үнэлгээ хийж дууссан. Тэнцсэн "Тал нутгийн хөгжлийн зам" ХХК-тай гэрээ байгуулах зөвшөөрлийг Засгийн газрын 2018 оны 10 сарын 31-ний өдрийн 329 дүгээр тогтоолоор Үндэсний хөгжлийн газарт олгосны дагуу 2019 оны 3 дугаар сарын 29-ны өдөр концессын гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 6 сарын хугацаанд концессын гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлүүдийг нэг ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар батлуулсан. ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна.
70	Өмнөд Буйрын 21 дүгээр талбайгаас Тосон-Уул-Баянхошуу боомт чиглэлийн авто замтай холбох 58.5 км хатуу хучилттай авто зам	"Их Монгол барилга" ХХК	2018.11.05-2020.11.05	3.0%	3.3%	0.3%	Захиалагч "Петрочайна Дачин Тамсаг" нь зураг төсөл боловсруулах Зөвлөхөөр "Ай Си Ти Сайн консалтинг" ХХК-ийг сонгон 2017.11.13-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд "Ай Си Ти Сайн консалтинг" ХХК нь зураг төслийг боловсруулан экспертизээр батлуулж 2018 оны 8 сард хүлээлгэн өгсөн. Зам барилгын ажлын гүйцэтгэгчээр "Их Монгол барилга" шалгарсан. Гүйцэтгэгч ажлын талбайд 4 дүгээр сарын 15-ны өдөр гарсан бөгөөд одоогоор 19.5 км хөрс хуулж, 97 200 м3 далангийн дүүргэлтийн ажил /20.8 %/ хийгээд байна.